



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2015 оны 08 сарын 09 өдөр

Дугаар А/А25

Мөрөн

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “г”, “а” дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.3 дэх заалт, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, 15.5 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Нисэх буудал дээр зохион байгуулагдсан “Эрүүл мэндийн холбогдолтой үүссэн онц байдал” бүрэн хэмжээний сургуулилтын зардалд 630000 төгрөг, Ардчилсан хөдөлгөөн үүсэн байгуулагдсаны 25 жилийн ойн арга хэмжээнд Хөвсгөл аймагт оролцогчдын байр, хоолны зардалд 760000 төгрөг, Мөрөн сумын хяналтын камерын 1-4 дүгээр сарын цахилгааны зардалд 2265500 төгрөг, амьдрал эрүүл мэндийн байдлыг харгалзан Мөрөн сумын 5 дугаар багын иргэн Д.Оюунсайханд 100000 төгрөгийн буцалгүй тусламжийг олгосугай.

2. Шаардагдах 3755500 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Г.Төмөрбаатар/, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/ нарт зөвшөөрсүгэй

ДАРГА



А.ЭРДЭНЭБААТАР